

Электрон тайлангийн программын заавар

Аж ахуйн нэгж байгууллагууд дараах хаягаар орж электрон тайлан өгнө.

<http://e-tax.mta.mn/>

1. Системд нэвтрэх

ТТД Татвар төлөгчийн дугаар нь улсын бүртгэлийн албанаас өгсөн 7 оронтой дугаар байна

Нэвтрэх үг Татварын албанаас гэрээ хийжэд өгсөн нэвтрэх үг байна.

Татвар төлөгчийн дугаар нүдэнд өөрийн байгууллагын улсын бүртгэлийн 7 оронтой дугаарыг бичиж өгнө.

Нэвтрэх үг нүдэнд татварын албанаас өгсөн нэвтрэх үгийг оруулж эхний удаа системд нэвтрэнэ. Энэ 5 оронтой тоогоор бичигдсэн нууц үг байна. Та системд нэвтрэсний дараа **Нэвтрэх үг солих** гэсэн линк дээр дарж татварын албанаас өгсөн нэвтрэх үгийг өөрчилөх ёстой.

Нэвтрэх товч дээр дарж системд нэвтрэнэ.

2. Электрон тайлангийн цонх

Та системд амжилттай нэвтэрсэн бол дараах цонх нээгдэнэ.

ЭЛЕКТРОН ТАЙЛАН


2007 оны 9 сарын 9 өдөр

- 1 Интернетээр тайлан өгөх
- 2 Тайлангаа хэвлэж авах
- 3 Татварын албаны нэг цэгийн үйлчилгээнд тайлангаа өгөх

3. НӨАТ – ын тайлан оруулах


Алхам 1

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан өгөхийн тулд зүүн гар талд байрлах линкүүдээс *электрон тайлан* гэсэн линк дээр дарна.




Алхам 2

Электрон тайлан гэсэн линк дээр дарсны дараа дэлгэцэнд дараах цонх нээгдэнэ. Эндээс *Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан* гэсэн линк дээр дарна.



Алхам 3

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан гэсэн линк дээр дарсны дараа дэлгэцэнд нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн маягт нээгдэнэ. НӨАТ-ын тайлангийн хувьд **тайлант хугацаа** тавигдсан байна. Энэ хугацаа нь тайлан өгөх хугацаанд идэвхтэй байна. Жишээ нь : 2007 оны 10 сарын 1-нээс 10-ны хооронд 2007 оны 9 сарын тайланг хүлээн авахаар тайлант хугацаа автоматаар гарч ирсэн байна. Тиймээс энэ хугацааны хооронд л тайлангаа өгнө. Тайлан бөглөхдөө **мянгачилж** дүнг оруулна. Тайлангийн маягтын **бүдэг цэнхэр өнгөтэй** нүднүүдэд тоо шивэж өгнө. **Цагаан өнгөтэй** нүднүүд томъёогоор шууд бодогдоно. Жишээ нь 7-р мөр буюу бараа борлуулсын орлого гэсэн нүд нь 8-аас 13-р нүднүүдэд бичигдсэн тооны нийлбэр байна. Тухайн сарын НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалтыг хийхдээ 38 – 41-р мөрүүд дээр тоо бичих бол урд талын **--Сонголт хийх--** гэсэн хэсгээс хамаарах хуулийн заалтыг заавал сонгож өгнө. Хэрвээ **НӨАТ ногдох ажил, үйлчилгээ эрхлээгүй** бол чагталж өгнө. Энэ тохиолдолд аль ч нүдэнд тоо шивэх боломжгүй болно. Андуурч чагталсан бол чагтыг авахад тоо шивэх боломжтой болно. Тайлангийн маягтыг бөглөж дууссаны дараа **Хадгалах** гэсэн товч дээр дарна.



Үндэсний Татварын Ерөнхий Газар

Маягт ТТ-03

Нэмэгдсэн өртгийн албан татварын сарын тайлан

ТТД : 2663341 Нэр : ИХЕВЭН АЖИЛ Хэрвээ Х тайлан өгөх бол энд тэмдэглэнэ.

Тайлангийн хугацаа : Он : 2007 Сар : 09 НӨАТ ногдох ажил, үйлчилгээ эрхлээгүй бол энд тэмдэглэнэ

Анхаар Бүдэг цэнхэр өнгөтэй нүдэнд тоо шивнэ. Бусад нүднүүд шууд бодогдоно. НӨАТ-ын тайланг МЯНГАЧИЛЖ (МЯНГАН ТӨГРӨГ) оруулна

А.ТУХАЙН САРЫН БОРЛУУЛСАН БАРАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО			
Тухайн сарын нийт борлуулалт	5		10370.0
Тухайн сарын бараа, ажил, үйлчилгээний нийт борлуулалт	6		10320.0
Бараа борлуулсны орлого	7		10020.0
Дотоодын зах зээлд борлуулсан бараа			10000
Аж ахуй болон бизнес эрхлэх эрх жуда			
Тухайн сарын НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалт	37		50.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын	38		50
үүнд: -- Сонголт хийх --	39		
-- Сонголт хийх --			
-- Сонголт хийх --			
Тухайн сарын нийт борлуулалт НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалт	42		4820.0
ТУХАЙН САРД СУУТГАН ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ	73		0.0
Г.СУУТГАСАН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО			
Нийт төлбөл зохих НӨАТ	74		1032.0
Нийт буцаан авах НӨАТ	75		0.0
ЭЦСИЙН ТООЦООГООР ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ	76		1032.0
ЭЦСИЙН ТООЦООГООР БУЦААН АВАХ НӨАТ	77		0.0

Бүдэг цэнхэр өнгөтэй нүдэнд тоогоо бичиж оруулна. Тоог мянгачилж шивнэ. Цэгээр нарийвчлалыг оруулж өгнө.


Чөлөөлөгдөх борлуулалтын төрлийг эндээс сонгоно

Хадгалах

Тайлан бөглөж дууссаны дараа хадгалах гэсэн товч дээр дарна.

Алхам 4

Хадгалах товч дарахад дараах асуух цонх нээгдэнэ.



Хэрвээ та тайлангаа мянгачилж зөв оруулсан болон таны **төлбөл зохих, буцаан авах** татварын дүн таарч байгаа бол **OK** товч дээр дарна. Таны тайлан татварын албаны мэдээллийн санд хадгалагдана. Хэрвээ дүнгүүд таарахгүй байгаа бол **Cancel** товч дээр дарж тайлангаа зассаны дараа дахин хадгалана уу.

4. НӨАТ-ын тайлан илгээх

НӨАТ-ын тайланг хадгалсны дараа тухайн тайлангаа зөв бүрэн оруулсан эсэхийг шалгана. Тайлангаа зөв оруулсан гэж үзэж байгаа бол тайлангийн доод хэсэгт байрлах **Илгээх** гэсэн товч дээр дарна. Буруу оруулсан бол **Устгах** гэсэн товч дээр дарж устгасны дараа дахин тайлангаа оруулж өгнө.

Илгээх гэсэн товч дээр дарсан тохиолдолд татварын албаны мэдээллийн санд шууд бүртгэгдэнэ. Энэ тохиолдолд тухайн тайланг устгах боломжгүй болно. Иймээс **Илгээх** товчоо дарахын өмнө тайлангийн үзүүлэлтээ шалгах ёстой.

Таны оруулсан тайлан амжилттай хадгалагдлаа. Та тайлангаа зөв оруулсан эсэхээ шалгаад татварын албанд илгээнэ үү.

Маягт
ТТ-03

Үндэсний Татварын Ерөнхий Газар



Нэмэгдсэн өртгийн албан татварын сарын тайлан

ТТД : 2663341

Нэр : Иххөвчийн жонон

Тайлангийн хугацаа : Он : 2007 Сар : 09

НӨАТ ногдох ажил, үйлчилгээ эрхлээгүй бол энд тэмдэглэнэ

А.ТУХАЙН САРЫН БОРЛУУЛСАН БАРАА, ГҮЙЦЭГТЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭГ ДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО			
Тухайн сарын нийт борлуулалт		5	10,370.0
Тухайн сарын бараа, ажил, үйлчилгээний нийт борлуулалт		6	10,320.0
Үүнээс	Бараа борлуулсны орлого	7	10,020.0
	Дотоодын зах зээлд борлуулсан барааны борлуулалтын орлого	8	10,000.0
	Аж ахуй болон бизнес эрхлэх эрх худалдсаны орлого	9	
	Татан буугдах үед өөрт үлдээсэн барааны орлого	10	
	Бусад этгээдэд ерийн төлбөр болгон өгсөн барааны орлого	11	20.0
	Экспортлосон барааны борлуулалтын орлого	12	
Оршин суугч бус иргэн, хуулийн этгээдээс уг бараа, ажил, үйлчилгээг импортлох болон худалдаж авахад төлсөн НӨАТ		72	
ТУХАЙН САРД СУУТГАН ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ		73	-
Г.СУУТГАСАН НЭМЭГ ДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО			
ҮҮНД :	НИЙТ ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ	74	1,032.0
	НИЙТ СУУТГАН АВАХ НӨАТ	75	-
	ЗӨВ ОРУУЛСАН ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ	76	1,032.0
	БУРУУ ОРУУЛСАН ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ	77	-
	УСТАХ НӨАТ		

Илгээх гэсэн товч дээр дарж илгээнэ.

Илгээх Тайлангаа үнэн зөв шивсэн бол илгээх гэсэн товч дээр дарна уу.

Устгах Тайлангаа алдаатай буруу шивсэн бол устгах гэсэн товч дээр дарна уу.

Буруу шивсэн бол устгах гэсэн товч дээр дарна.

5. НӨАТ – ын падааныг илгээх

Алхам 1

Нэмэгдсэн өртгийн албан татварын **ПАДААН ШИВЭХ ПРОГРАМ**-аар оруулсан падаануудыг export хийхэд үүссэн файлыг **C:\vatdatas** фолдер дотроос зааж илгээнэ. Падаан шивэх програмаар үүсэх файл нь доорхи форматтай байна. **DDDDDDD_YYYYMM.xml** нэртэй байна. **DDDDDDD-Татвар төлөгчийн дугаар, YYYY-тайлант он, MM-тайлант сар** байна. Та файлаа зааж өгөхийн тулд **Browse...** товч дээр дарна.

Ногдол	Төлөлт	Үлдэгдэл	Электрон тайлан	Гарах
Иххөвчийн жонон		ТТД : 2663341	Хэрэглэгчийн хандалт : 1	


Таны хадгалсан тайлан татварын албанд амжилттай илгээгдлээ. Та одоо НӨАТ-ын падаан шивэх програмаар бэлтгэсэн файлаа илгээнэ үү.

НӨАТ-ын падаан илгээх	
НӨАТ -ын падаан шивэх програмаар бэлтгэсэн тухайн сарын файлыг илгээнэ үү.	
Файлын нэр :	<input type="text"/> <input type="button" value="Browse..."/> <input type="button" value="Файл илгээх"/>

НӨАТ-ын падаан шивэх програмаар
төсөө н файлыг энд дарж зааж өгнө.

Алхам 2

Browse... товч дээр дарахад дараах цонх нээгдэнэ. **C:\vatdatas** фолдер тухайн татвар төлөгчийн тайлант хугацаанд хамаарах файлыг зааж өгнө.



Алхам 3

Файлаа зөв сонгосны дараа **Файл илгээх** гэсэн цонх дээр дарж илгээнэ.

Таны оруулсан тайлан амжилттай хадгалагдлаа

НӨАТ-ын падаан илгээх
НӨАТ -ын падаан шивэх програмаар бэлтгэсэн тухайн сарын файлыг илгээнэ үү.
Файлын нэр : C:\watdatas\2663341_200708.xml

Таны илгээх файлын нэр энд гарч ирнэ.

Файл илгээх гэсэн товч дээр дарна.

Алхам 4

Хэрвээ таны файл амжилттай илгээгдсэн бол НӨАТ-ын падааны жагсаалт падаан бүрээрээ дараах зурагт үзүүлсэн жишээтэй адил харагдана.

Таны илгээсэн 2663341_200708.xml файлыг хүлээн авлаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан

Татвар төлөгчийн дугаар : 2030586

Нэр : Сэцэн

Эхний он.сар.өдөр : 2007-08-01

Сүүлийн он.сар.өдөр : 2007-09-01

	Борлуулалтын падаан дүн	Худалдан авалтын падааны дүн
Бараа, ажил, үйлчилгээний үнэ		
Нэмэгдсэн өртгийн албан татвар		
Нийт дүн		

Падааны дугаар : 12345678

Он.сар.өдөр : 8/14/2007

Борлуулагч

Худалдан авагч

Нэр : Сэцэн

Нэр : Ди Энд Эн


ТТД : 2030586

ТТД : 2634996

Д/Д	Бараа, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Арьс болон савхин эдлэл		20	100	2000
2	Боловсруулаагүй тамхи		500	300	150000
Бараа, ажил, үйлчилгээний үнэ :					152000
Нэмэгдсэн өртгийн албан татвар :					15200
Нийт дүн :					167200

6. НӨАТ – ын тайлангаа харах

Алхам 1



Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан

- Бичлэг байхгүй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан

- [2007 оны 03 сарын тайлан](#)

Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан

Бичлэг байхгүй байна.

Тайлангийн жагсаалт линк дээр дарна.

Алхам 2



Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан

- Бичлэг байхгүй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан

- [2007 оны 03 сарын тайлан](#)

Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан

Бичлэг байхгүй байна.

Хадгалсан тайлангийн линк дээр очиж дарна.

Алхам 3

Маягт
ТТ-03

Үндэсний Татварын Ерөнхий Газар



Нэмэгдсэн өртгийн албан татварын сарын тайлан

ТТД : 2663341

Нэр : **Иххөвчийн хонон**

Тайлангийн хугацаа : Он : 2007 Сар : 09

НӨАТ ногдох ажил, үйлчилгээ эрхлээгүй бол энд тэмдэглэнэ

А. ТУХАЙН САРЫН БОРЛУУЛСАН БАРАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО			
Тухайн сарын нийт борлуулалт		5	10,370.0
Тухайн сарын бараа, ажил, үйлчилгээний нийт борлуулалт		6	10,320.0
Үүнээс	Бараа борлуулсны орлого	7	10,020.0
	Дотоодын зах зээлд борлуулсан барааны борлуулалтын орлого	8	10,000.0
	Аж ахуй болон бизнес эрхлэх эрххүдэлдсаны орлого	9	
	Татан буугдах үед өөрт үлдээсэн барааны орлого	10	
	Бусад этгээдд өрийн төлбөр болгон өгсөн барааны орлого	11	20.0
	Экспортлосон барааны борлуулалтын орлого	12	
	Бусад барааны борлуулалт	13	
Ажил, үйлчилгээ борлуулсны орлого		14	300.0
	Цажилгаан борлуулсны орлого	15	
	Дулааны эрчим хүч борлуулсны орлого	16	300.0
	Хий /уур/ борлуулсны орлого	17	
	Ус хангамж, ариутгах татуургын борлуулалт	18	
	Шуудангийн үйлчилгээний орлого	19	
	Ухирдсан зөвхөн үйлчилгээний орлого	20	

7. Нэвтрэх үгээ солих

Та татварын албанаас өгсөн нэвтрэх үгээ өөрөө солиж болно.

Алхам 1.

Нэвтрэх үгээ солихдоо зүүн гар талд байрлах линкүүдээс **Нэвтрэх үг солих** гэсэн линк дээр дарна.

Алхам 2

Татварын албанаас өгсөн нэвтрэх үгийн та **Хуучин нэвтрэх үг** гэсэн нүдэнд шивж оруулна.

Шинэ нэвтрэх үг, шинэ нэвтрэх үг дахин оруул гэсэн доод талын 2 нүдэнд өөрийн шинээр өгөх нэвтрэх үгээ адилхан бичиж өгнө. Дараа нь **Хадгалах** гэсэн товч дээр дарна.

Хэрэглэгчийн нэвтрэх үг солих	
Хуучин нэвтрэх үг	<input type="text"/>
Шинэ нэвтрэх үг	<input type="text"/>
Шинэ нэвтрэх үг (дахин оруул)	<input type="text"/>
<input type="button" value="Хадгалах"/>	

Татварын албанаас өгсөн нэвтрэх үгээ бичнэ

Шинэ нэвтрэх үгээ оруулна.

Шинэ нэвтрэх дахин оруулна.

8. Системээс гарах

Та электрон тайлангийн үйлчилгээг ашиглаж дууссаны дараа заавал **Гарах** гэсэн линк дээр дарна.

Гарах гэсэн линк дээр дарна